



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн
чиглэлийн хөтөлбөрөөр оюутан элсүүлэхэд
зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн 2026-2027 оны хичээлийн жилд тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн чиглэлээр оюутан элсүүлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор ТУШААХ нь:

1. Тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн чиглэл заасан хөтөлбөр болон мэргэжлийн чиглэл (хөтөлбөрийн нэр) 05-09-д заасан ерөнхий чиглэлд хамаарах хөтөлбөрөөр элсэгчийг Боловсролын сайдын 2026 оны "Босго оноог тогтоох тухай" А/34 дугаар тушаалын хавсралт дахь "Элсэлтийн шалгалт-1"-д заасан хоёр судлагдахууны аль нэгийг, "Элсэлтийн шалгалт-2"-т заасан аль нэг судлагдахуун, харгалзах оноонд шилжүүлэн тооцож болно.

2. Тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн чиглэлд заасан хөтөлбөр болон мэргэжлийн чиглэл (хөтөлбөрийн нэр) 05-09-д заасан ерөнхий чиглэлд хамаарах хөтөлбөрөөр элсэгчийн ур чадварын шалгалтын оноог А/34 тушаалын хавсралт дахь "Элсэлтийн шалгалт-2"-т заасан судлагдахууныг 490 ба түүнээс дээш оноогоор дүйцүүлэн тооцож болно.

3. Дээд боловсролын сургалтын байгууллагад 2026-2027 оны хичээлийн жилд шинээр элсэгчдийг энэхүү тушаалд заасны дагуу дээд боловсролын удирдлага, мэдээллийн системд бүртгэх арга хэмжээ авахыг Боловсролын ерөнхий газар (Х.Тамир)-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Л.Төгсбаяр)-т даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

1426010223